

ҮНДЭСНИЙ
ХУВЬЧЛАЛЫН
САН

ЖИЛИЙН ТАЙЛАН | **2021**

ЭРХЭМ ХҮНДЭТ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНАА

2021 он цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хувьд хүндхэн жил байсан хэдий ч Монголын хөрөнгийн зах зээл гайхалтай өндөр өсөлтийг үзүүлсэн жил болж өнгөрлөө. Монголын Хөрөнгийн Биржийн Топ20 индекс 2021 онд 130%-ийн өсөлтийг үзүүлж дэлхийн хамгийн өндөр өсөлттэй индексээр тодорчээ.

Үндэсний Хувьчлалын Сан (цаашид ХОС гэх)-ийн хувьд 2021 онд дотоодын хөрөнгийн зах зээлд түлхүү хөрөнгө оруулах урт хугацааны хөрөнгө оруулалтын стратегийг хэрэгжүүлж ажилласан бөгөөд тогтмол өгөөж бүхий хэрэгслийн нийт багцад эзлэх хэмжээг 30% хүртэл бууруулж, хувьцааны багцыг нэмэгдүүлж ажиллаа. Үүний үр дүнд сангийн цэвэр хөрөнгийн хэмжээ ₮4.9 тэрбумаас ₮9.3 тэрбумд хүрч 91.2%-аар өссөн үр дүнтэй 2021 оноо үдэж байна. Зах зээлийн үнэлгээний хувьд оны эцэст ₮9.95 тэрбумд хүрсэн нь оны эхнээс 83.2%-аар өссөн үзүүлэлт байна. Сангийн нэгж эрх эзэмшигчдийн тоо 2021 онд 2.6 дахин өсөж 6,325-д хүрсэн бол хөрөнгийн бирж дээрх ХОС-ийн нийт арилжааны эргэлт ₮6.85 тэрбум төгрөг хүрч биржийн идэвхтэй арилжаалагддаг үнэт цааснуудын нэгээр тодроод байна.

Засгийн газар болон Төв банкнаас авч хэрэгжүүлсэн мөнгөний зөөлөн болон сангийн тэлэх бодлогын нөлөөгөөр зах зээл дэх мөнгөний нийлүүлэлт нэмэгдэж, хүүгийн төвшин бүх цаг үеийн хамгийн доод төвшинд хүрсэн нь хөрөнгийн зах зээлд эерэгээр нөлөөлжээ. Нөгөө талаас улсын инфляц 2021 оны эцсийн байдлаар жилийн 13.4%-д хүрч өссөн нь хөрөнгө оруулагчдыг илүү өндөр өгөөж эрэлхийлэх гол шалтгаан болж байна. Жишээ нь 2021 оны эхэнд 1 жилийн хугацаатай хадгаламж 8%-ийн хүүтэй байршуулсан бол инфляцын нөлөөгөөр хадгаламж дахь мөнгөний үнэ цэнэ $13.4\% - 8\% = 5\%$ -аар буурсан байна.

Дэлхий даяар өндөр инфляцтай нүүр тулж буй тул 2022 онд төв банк болон засгийн газрын бодлогын шилжилт хийгдэх магадлал тун өндөр байгаа тул хөрөнгийн зах зээлд томоохон савлагаа үүсэх төлөвтэй байна. 2022 онд 2021 оны амжилтаа бататгаж, болзошгүй эрсдэлээс сэргийлэх, багцын эрсдэлийг бууруулах тал дээр түлхүү анхаарч ажиллах болно.

Ард Менежмент ҮЦК ХХК

Гүйцэтгэх захирал

Ч.Хандаа

АГУУЛГА

4	Таны хөрөнгө оруулалтын сангийн гүйцэтгэл
5	Товч танилцуулга
8	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд
14	Нэгж эрх эзэмшигчдийн бүтэц
15	Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл
19	Ногдол ашиг тараахгүй тухай шийдвэр
20	Нэгж эрхийн арилжаа
21	Сангийн менежерийн үйл ажиллагааны тайлан
22	2021 оны эдийн засгийн тойм
26	2022 оны төсөөлөл
29	Хараат бус аудитын тайлан

ТАНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ГҮЙЦЭТГЭЛ

- Үндэсний Хувьчлалын Сан хамтын ХОС (MSE:XOC) нь 2020 оны 10-р сард үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш 1 жил 2 сарын хугацаа өнгөрчээ. Энэ хугацаанд сангийн цэвэр хөрөнгийн дүн ₮5 тэрбумаас ₮9.3 тэрбумд хүрч онцгой өсөлтийг үзүүлжээ. 2021 оны эцсийн байдлаар нэгж эрхэд ногдох цэвэр хөрөнгийн үнэлгээ 186.51 хүрч оны эхнээс 91.2%, зах зээлийн үнэ 199.01 хүрч оны эхнээс 83.2%-иар тус тус өссөн байна. ХОС-ын зорилтот өгөөжийн хэмжээ жилийн 17.6% бөгөөд 2021 оны хувьд зорилтоос даруй 72.2%-ийн өндөр өгөөжтэй ажиллажээ.
- ХОС-ын хувьд Монголын Хөрөнгийн Бирж дээр арилжаалагддаг хувьцаануудад түлхүү хөрөнгө оруулалт хийж ажилласан. 2021 оны эхэнд багцын томоохон хэсгийг бүрдүүлж байсан хадгаламжийн хэмжээг бууруулж компанийн бонд болон хувьцааны хөрөнгө оруулалтад шилжүүлсэн нь сангийн өгөөжид эерэгээр нөлөөлсөн байна.

Хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн өгөөжийн харьцуулалт

	2018	2019	2020	2021
Үндэсний Хувьчлалын Сангийн өгөөж			25.6%	91.2%
ТОП-20-ийн өгөөж	3.5%	-8.6%	-1.7%	130%
Хадгаламжийн хүү	14.1%	13.5%	11.3%	~9%

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж, Монголбанк

ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САНГИЙН ТОВЧ ГҮЙЦЭТГЭЛ

Тикэр
ХОС

Гаргасан нэгж эрх
50 сая ширхэг

Нэгж эрх эзэмшигчийн тоо
6,325

Нэгж эрхийн хаалтын ханш
₮199.01

Зах зээлийн үнэлгээ
₮9.95 тэрбум

Жилийн арилжааны эргэлт
₮6.85 тэрбум

Нэгж эрхийн NAV
₮186.51

Нийт цэвэр хөрөнгө NAV
₮9.33 тэрбум

Дэлгэрэнгүй орлого
₮4.4 тэрбум



ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Сангийн мэдээлэл

“Үндэсний Хувьчлалын Сан” хамтын хөрөнгө оруулалтын сан нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийн эрхтэй, тусгай зориулалтын компани юм.

Нэр	“Үндэсний Хувьчлалын Сан” хамтын хөрөнгө оруулалтын сан
Сангийн хэлбэр	Хаалттай хамтын хөрөнгө оруулалтын сан
Үйл ажиллагаа	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх
Хугацаа	Үүсгэн байгуулагдсан хугацаа: 2019-8-7 Үйл ажиллагаа явуулах хугацаа: 10 жил
Сангийн татан төвлөрүүлсэн хөрөнгө	5,000,000,000 төгрөг
Хөрөнгө итгэмжлэн удирдах компани	“Ард Менежмент ҮЦК” ХХК
Хөрөнгө хадгалах компани	“Голомт Банк” ХХК-ийн кастодиан банкны хэлтэс
Хаяг	- Монгол Улс, СБД, Ерөнхий Сайд Амарын гудамж, “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн байр, 2 давхар - Утас: 976-11-70078080 - И-мэйл: info@ardmanagement.mn - Вэб сайт: ardmanagement.mn

Сангийн зорилго

Сан нь Монгол Улс болон дэлхий даяар арилжаалагддаг үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийн, түүнээс бий болох ашгийг хөрөнгө оруулагчдадаа хуваарилахаар зорьж ажилладаг.

- Улс орны эдийн засагт томоохон байр суурь эзэлдэг төрийн өмчит компаниудын хувьчлалд оролцож, компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, үнэлгээг өсгөх замаар урт хугацаанд өгөөж хүртэх;
- Дунд хугацаанд Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нээлттэй хувьцаат компанийн хувьцаа, бондод хөрөнгө оруулалт хийж, өгөөж хүртэх;
- Мөнгөн урсгал, хөрвөх чадварыг тогтвортой байлгаж, эрсдэлийг багасгахын тулд засгийн газрын үнэт цаас, компанийн бонд, банкны хадгаламж зэрэг тогтмол орлоготой хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд хөрөнгө оруулалт хийн өгөөж хүртэх.

Хөрөнгө оруулалтын бодлого

Үндэсний Хувьчлалын Сан нь хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд тооцоо судалгаа хийсний үндсэн дээр хөрөнгө оруулалт хийдэг бөгөөд сангийн нийт хөрөнгийн 70 хүртэлх хувиар дотоод болон гадаадын хөрөнгийн зах зээлд бүртгэлтэй хувьцаат компанийн хувьцаанд хөрөнгө оруулалт хийж ажилладаг. Ингэхдээ компанийн суурь шинжилгээ, зах зээлийн судалгаа зэргийг багтаасан мэргэжлийн судалгаа шинжилгээнд үндэслэн хөрөнгө оруулалт хийдэг болно.



Галбадрахын Цогбадрах

**“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” хамтын
ХОС-ийн ТУЗ-ийн дарга**

Мэргэжил: Эдийн засагч, санхүүч

ТУЗ-ийн дарга

Г.Цогбадрах нь 1997 онд Монгол Улсын Их Сургуулийг банкны эдийн засагч мэргэжлээр төгссөн бөгөөд ажлын гараагаа суралцаж байх хугацаандаа буюу 1996 онд Голомт Банканд ажиллаж эхлүүлсэн байна. Тэрээр 2000 оноос Хас Банкны санхүү, дотоод аудит, салбарын удирдлага, хөрөнгө зохицуулалтын газрын захирлаар тус тус ажиллаж байгаад 2009-2010 онд АНУ-ын Үндэсний Их Сургуульд бизнес удирдлага мэргэжлээр магистрын зэрэг хамгаалсан. 2010 онд “Тэнгэр Санхүүгийн Нэгдэл” ХХК-ийн хөрөнгө оруулалт хариуцсан захирлаар ажиллаж байгаад 2011 оноос 2014 оны хооронд “Тэнгэр Даатгал” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар томилогдон ажилласан. 2016 оноос “Ард Даатгал” ХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.



Батбилэгийн Золбоо

**“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” хамтын
ХОС-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн**

Мэргэжил: Эдийн засагч

ТУЗ-ийн ердийн гишүүн

Б.Золбоо нь 2012 онд Санхүү Эдийн Засгийн Дээд Сургуульд олон улсын нягтлан бодогч мэргэжлээр сурч байгаад 2013-2016 онд АНУ-ын Платсбүрг Коллеж (Plattsburgh college)-ийг эдийн засагч мэргэжлээр төгссөн. 2016-2017 онд “Ард Секюритиз ҮЦК” ХХК-д хөрөнгө оруулалтын шинжээч, 2017 оноос “Ард Менежмент ҮЦК”-ХХК-ийн үйл ажиллагаа хариуцсан захирлаар тус тус ажиллаж байгаад 2019 оноос “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-д санхүү хариуцсан захирлаар ажиллаж эхэлсэн байна.



Ч Хандаа

“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” хамтын ХОС-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн

Мэргэжил: Эдийн засагч, банк санхүүгийн менежмент

ТУЗ-ийн ердийн гишүүн

Ч.Хандаа нь 2005 онд МУИС-ийг эдийн засагч мэргэжлээр төгссөн бөгөөд 2006 оноос эхлэн одоогийн “Ард Секьюритиз ҮЦК” ХХК-д ажиллаж эхэлсэн. Ажиллах хугацаандаа 2006-2010 онд брокер, дилер, 2010-2012 онд хөрөнгийн зах зээлийн хэлтсийн захирал, 2012 оноос гүйцэтгэх захирлаар тус тус ажилласан. 2015 оноос эхлэн “Ард Менежмент ҮЦК” ХХК-д гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. Ч.Хандаа нь 2018 оноос “ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажлыг удирдаж амжилттай хэрэгжүүлсэн болно. Ч.Хандаа нь хөрөнгийн зах зээл, компанийн үнэлгээ, андеррайтер, судалгаа, шинжилгээ, санхүүгийн менежер зэрэг чиглэлүүдээр мэргэшсэн туршлагатай бөгөөд хөрөнгийн зах зээлд нийт 13 жил ажилласан билээ.



Пүрэвийн Баянсан

**“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” ХХК-ийн
ТУЗ-ийн хараат бус гишүүн**

Мэргэжил: Бизнесийн удирдлага

ТУЗ-ийн хараат бус гишүүн

П.Баянсан нь 1995-1999 онд бизнесийн удирдлагын бакалавр, 1999-2001 онд бизнесийн удирдлагын магистр, 2004 онд Монгол Улсын Их Сургуулийн Эдийн Засгийн Сургуульд “Засгийн газрын үнэт цаасанд хөрөнгө оруулагчдын бүтцийг оновчлох асуудал” сэдвээр докторын зэрэг хамгаалсан. Одоо Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ТӨХК-ийн хараат бус гишүүн болон Монголын Мэргэшсэн Үнэлгээчдийн Институтийн Удирдах зөвлөлийн гишүүнээр тус тус ажиллаж байна.



**ТУЗ-ийн хараат бус
гишүүн**

Баяраагийн Баасандорж

**“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” хамтын
ХОС-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн**

Мэргэжил: Эрх зүйч

Б.Баасандорж нь 2005-2010 онд Монгол Улсын Их Сургуулийн Хууль Зүйн Сургуулийг олон улсын эрх зүйч, 2012-2015 онд БНХАУ-ын Төв Хятадын Хууль Зүйн Сургуулийг хууль зүйн магистраар төгссөн. Ажлын туршлагын хувьд 2010-2011 оны хооронд “Энержи Ресурс” ХХК-д хуулийн мэргэжилтэн, 2013 оноос одоог хүртэл өмгөөллийн “Батбаяр энд Партнэрс” ХХН-д өмгөөлөгчөөр ажиллаж байна



Чадраабал Даваасамбуу

“Ард Менежмент ҮЦК” ХХК-ийн сангийн менежер

Мэргэжил: Санхүү удирдлага

Ч.Даваасамбуу нь 2017 онд МУИС Бизнесийн сургуулийг Санхүүгийн удирдлагын бакалавр зэрэг хамгаалсан. Хөрөнгө оруулалт, хөрөнгийн удирдлага, арилжааны чиглэлээр 4 жил ажилласан туршлагатай. Үүнд 2017 оноос 2022 он хүртэл “Ард Секюритиз ҮЦК” ХХК-ийн санхүүгийн шинжээч, ахлах санхүүгийн шинжээч болон дилерээр тус тус ажиллаж байсан туршлагатай.



НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

2021 оны эхэнд Үндэсний Хувьчлалын Сангийн нэгж эрх эзэмшигчдийн тоо 2,451 байсан бол оны эцсийн байдлаар 6,325-д хүрч 2.6 дахин өссөн байна. Нэгж эрх эзэмшигчдийн тооны өсөлтөөс харвал сангийн үйл ажиллагаа сайн байгаа болон хөрөнгө оруулалтын сангийн эрэлт хэрэгцээ зах зээл дээр их байгаа зэргийг харж болж байна.

Нэгж эрх эзэмшигч	Нэгж эрхийн тоо	Хувь
Ард Даатгал ХК	5,734,408	11%
Хувь Хүн	3,000,000	6%
М Си Эс Инвестмент ХХК	2,500,000	5%
Ард Менежмент ҮЦК ХХК	2,500,000	5%
Ард Кредит ББСБ ХК	1,558,998	3%
Богд Банк ХХК	1,371,500	3%
Хувь Хүн	1,000,000	2%
Хувь Хүн	1,000,000	2%
Хувь Хүн	807,141	2%
Монре Даатгал ХХК	500,000	1%
Бусад 6315	30,027,953	60.0%
Нийт	50,000,000	100.00%

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ

ХОС нь 2021 онд Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгэлтэй хувьцаанд түлхүү хөрөнгө оруулалт хийж ажиллаа. Цэвэр хөрөнгийн үнэлгээ 2021 оны эцэст 9.3 тэрбум төгрөгт хүрч 91.2%-иар, зах зээлийн үнэлгээ нь 9.95 тэрбум төгрөгт хүрч 83.2%-иар тус тус өсжээ. Тайлант хугацаанд ХОС-ийн татварын дараах ашиг 4.45 тэрбум төгрөг, татварын зардал 512 сая төгрөг байлаа.

Сангийн нэгж эрхийн хаалтын ханш болон нэгж эрхийн үнэлгээний өөрчлөлт




	Зах зээлийн ханш	NAV(Цэвэр хөрөнгийн үнэ)
12/31/2021	199.01	186.51
Оны эхнээс %	+83.2%	+91.2%
Сан нээгдсэнээс хойш	+99%	+87%
2021 оны доод/дээд	107/654	102.6/206.85


Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

Тайлант хугацаанд Сангийн нийт хөрөнгө дүн 9.8 тэрбум төгрөгт хүрч оны эхнээс 92.3%-иар өссөн байна. Тайлант хугацааны туршид Сангийн хөрөнгийн бүтцийн өөрчлөлтийг харвал:

Тайлант хугацааны туршид сангийн хөрөнгийн бүтцийн өөрчлөлт



Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК




Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

ХОС-ын хувьд хөрөнгө оруулалтын бодлого болон зохицуулагч байгууллагын тогтоосон харьцаа үзүүлэлтийг өртгийн аргаар тооцсон хувь хэмжээгээр тооцдог бөгөөд харьцаа үзүүлэлтийн шаардлагыг бүрэн хангаж байгаа болно. Багцын дахин тэнцвэржүүлэлтийг богино хугацааны давтамжтай хийх нь урт хугацааны хөрөнгө оруулалтын стратегитай харшилддаг тул бид өртгийн аргаар тооцож харьцаа үзүүлэлтийг хангаж ажилладаг билээ. Шалтгаан нь бид багцад байгаа өсөлттэй хувьцааны хувийн жинг бууруулахгүй байх, уналттай хувьцааны хувийн жинг өсгөхгүй байх нь хөрөнгө оруулалтын зөв бодлого гэж үздэгт оршино.

Тайлант хугацаанд хадгаламжид байсан хөрөнгийг хувьцаа болон бондод байршуулж, бэлэн мөнгийг боломжит бага түвшинд барьж ажилласан. Багцын дийлэн хэсгийг хувьцааны багц эзэлж байгаа бөгөөд зах зээлийн ханшаар тооцвол багцын 82%, өртгийн аргаар тооцвол багцын 63%-ийг эзэлж байна.

Хувьцааны багц, эдийн засгийн салбараар (Зах зээлийн үнэлгээгээр болон өртгийн аргаар, нийт хөрөнгийн багцад эзлэх хэмжээ %)



Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

Эдийн засгийн нэг салбар дахь хөрөнгө оруулалтын хэмжээ сангийн хөрөнгийн 25%-с хэтрэхгүй байхаар журамлагдсан бөгөөд дээр дурдсанчлан өртгийн аргаар тооцоход харьцаа үзүүлэлтийг хангаж байна. 2021 оны 12-р сарын 31-ны байдлаар ХОС-ын хувьцааны багцад нийт 25 хувьцаа байгаа бөгөөд үүнээс 17 нь дотоодын хувьцаа, 8 нь гадаад хувьцаа байна. Салбараар нь харвал санхүүгийн 8, өргөн хэрэглээний 4, түүхий эдийн 3, аж үйлдвэрийн 2, тогтмол бус хэрэглээний 4, технологийн 3, харилцаа холбооны салбарын 1 хувьцаануудаас багц бүрджээ.

Сангийн зардал

Тайлан хугацаанд сангийн нийт хөрөнгийн өдрийн дундаж үлдэгдэл нь ₮8,116.4 сая төгрөг байсан бөгөөд зардлын нийт дүн нь 269.86 сая төгрөг болсон байна. Нийт хөрөнгийн дундаж үлдэгдлээс тооцсон нийт зардлын харьцаа нь 2021 онд 3.3% байна.

Зардлын задаргаа(Сая төгрөгөөр)




Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

Сангийн эрсдэлийн үнэлгээ

Тайлант хугацааны эцэст зах зээлийн үнэлгээгээр тооцвол багцын 82%-ийг эрсдэл өндөртэй хөрөнгө буюу хувьцаа эзэлж байгаа бол үлдсэн хэмжээг эрсдэл бага, тогтмол өгөөж бүхий хөрөнгүүд эзэлж байна.

Сангийн өдөр бүрийн цэвэр хөрөнгийн үнэлгээний (NAV) тоо мэдээнд тулгуурлан шинжилж үзвэл, эрсдэлийн үзүүлэлтүүд нь дараах байдалтай байна.

Өдрийн NAV хөдөлгөөний тархалт



Нийт ажиглалтын тоо 248 бөгөөд өдрийн стандарт хазайлт нь 1.6% буюу жилийн 25.6% болно. Эрсдэлгүй хүүг Монголбанкны бодлогын хүү болох 6%-р тооцвол Үндэсний Хувьчлалын Сангийн Sharpe ratio (эрсдэлээр жигнэсэн өгөөжийг илтгэдэг харьцаа) нь 3.0 гарч байгаа нь хөрөнгө оруулалтын сангуудын хувьд харьцангуй сайн үзүүлэлтэд тооцогддог байна.

НОГДОЛ АШИГ ТАРААХГҮЙ ТУХАЙ ШИЙДВЭР

Сангийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 22/01 тоот тогтоолоор “Үндэсний Хувьчлалын Сан” ХОС-ийн хөрөнгө оруулалтын бодлогод заасны дагуу 2021 оны цэвэр ашгаас нэгж эрх эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэр гаргалаа. ТУЗ нь ХОС-ийн нэгж эрхийн танилцуулга болон хөрөнгө оруулалтын бодлогын дагуу ногдол ашиг тараахгүй гэж шийдсэн болно.

НЭГЖ ЭРХИЙН АРИЛЖАА

Үндэсний Хувьчлалын Сан нь хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сан буюу гаргасан нэгж эрхээ эргүүлэн худалдан авах үүрэг хүлээдэггүй сан юм. Хөрөнгө оруулагчид нэгж эрхээ Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан өөр хоорондоо арилжаалах боломжтой байдаг бөгөөд сангийн хөрвөх чадвар сайн байх нь зах зээлийн ханш зөв тогтох үндэс болдог.

ХОС-ын нэгж эрхийн арилжааны эргэлт 2021 онд ₮6.85 тэрбум байгаа нь хөрвөх чадвар сайн байгааг илтгэж байна. Зах зээлийн ханш хамгийн дээд түвшиндээ 2021 оны 4-р сарын 23-ны өдөр 653.89 хүрч өссөн бол хамгийн доод ханш нь 2021 оны эхэнд 107 төгрөг байжээ. Арилжааны идэвхийн хувьд оны эхний хагаст өндөр байсныг харж болно.



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

САНГИЙН МЕНЕЖЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Үндэсний Хувьчлалын Сангийн менежер хөрөнгө оруулалтын сантай холбоотой хууль, дүрэм, журмын хүрээнд сангийн хөрөнгийг удирдаж, өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан ажиллаа. ХОС-ын цэвэр хөрөнгийн үнэлгээ 2021 онд 91.2% өссөн бөгөөд нэгж эрх эзэмшигчдийн тоо 2.6 дахин өсч 6,325-д хүрчээ. Сангийн менежерийн үндсэн ажлыг хөрөнгө оруулалтын болон үйл ажиллагааны гэж хоёр хувааж авч үзэж болох бөгөөд дараах ажлууд тогтмол болон тухай бүр хийгдсэн байна.

Сангийн хөрөнгийн удирдлагатай холбоотой ажлууд:

- Хөрөнгө оруулалтын багцыг удирдах. Сангийн өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор хадгаламжийн хэмжээг бууруулж хувьцаа, компанийн бондын хэмжээг нэмэгдүүлсэн. Нийт 850 арилжаагаар 23 хувьцаа, 2 бондын арилжаанд оролцсон байна.
- Хөрөнгө оруулалтын судалгаа, шинжилгээг тогтмол хийж, хөрөнгө оруулалтын боломжийг эрэлхийлэх.
- Хөрөнгө оруулалтын нарийвчилсан төлөвлөгөөг батлуулж, сангийн менежерийн эрхийн хүрээнд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах, зөвшөөрөгдсөн хэмжээнээс өндөр дүнтэй хэлцлүүдийг ТУЗ-н шийдвэрээр гүйцэтгэх.

Сангийн үйл ажиллагаатай холбоотой ажлууд:

- Сангийн үнэ ханшийн мэдээллийг өдөр бүр олон нийтэд хүргэх.
- Улирал бүр ТУЗ-ийн хурлыг хуралдуулж сангийн үйл ажиллагаа, үр дүнг танилцуулах, шаардлагатай шийдвэрүүдийг гаргуулах.
- Улирал бүр Earning Call хийж сангийн үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээллийг олон нийтэд хүргэх.
- Зохицуулагч байгууллагуудтай харилцах.
- Кастодиан банканд сангийн хөрөнгийг хадгалуулах, тайлан мэдээний үнэн зөв байдалд хяналт тавих.
- Сангийн хагас жилийн болон бүтэн жилийн тайланг бэлтгэж олон нийт болон зохицуулах байгууллагад хүргүүлэх.
- СЗХ-ны хяналт шалгалт болон хөндлөнгийн аудит хийлгэх, холбогдох материалыг бүрдүүлэх, үүрэг даалгаврыг биелүүлэх.

2021 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

2021 он эдийн засгийн сэргэлтийн жил болно гэсэн хүлээлт оны эхэнд зах зээл дээр үүсээд байлаа. 2020 онтой харьцуулахад дэлхийн эдийн засаг өсөлттэй жил болсон хэдий ч цар тахлын тодорхойгүй байдал, сөрөг нөлөө үргэлжилсэн хэвээр байна. Улс орнууд цар тахлын эсрэг хэрэгжүүлсэн бодлого нь ерөнхийдөө ижил байсан нь вакцинжуулалт, мөнгөний зөөлөн бодлого, төрөөс аж ахуй нэгж, иргэдэд хөнгөлөлт, тусламж үзүүлэх зэрэг байлаа. Хүү буурсан, мөнгөний нийлүүлэлт нэмэгдсэн зэрэг нь хөрөнгийн зах зээл өсөх төгс орчинг бүрдүүлсэн бол уг бодлогын сөрөг нөлөө нь дэлхийн тээврийн сүлжээний доголдол, инфляцын өндөр өсөлт зэргээр ажиглагдаж байна. Дэлхийн голлох улс орнуудын ДНБ өсөлт болон инфляцын хэмжээг харвал 2020 оноос өссөн дүр зураг ажиглагдаж байна


ДНБ болон инфляцын жилийн өсөлтийн харьцуулалт(2020, 2021 он)

Эдийн засгийн үзүүлэлт	Улс	2020	2021	Зөрүү
ДНБ жилийн өсөлт	Монгол	-4.6%	4.6%	9.2%
	АНУ	-3.40%	5.60%	9.0%
	БНХАУ	2.20%	8.10%	5.9%
	ЕХ	-6.40%	5.10%	11.5%
	Дэлхий	-3.10%	5.90%	9.0%
инфляцын жилийн өсөлт	Монгол	2.3%	13.4%	11.1%
	АНУ	1.20%	4.70%	3.5%
	БНХАУ	2.50%	0.90%	-1.6%
	ЕХ	0.30%	2.60%	2.3%
	Дэлхий	3.20%	4.30%	1.1%

Эх сурвалж: Блүүмбэрг

2021 оны хувьд дэлхийн голлох хөрөнгийн захын индексүүд ихэнх нь өсөлттэй байсан бол БНХАУ-ын засгийн газрын бодлогоос үүдэлтэйгээр Хятадын хөрөнгийн захын индексүүд уналттай байлаа.


Голлох хөрөнгийн захын индексийн жилийн өөрчлөлт



Эх сурвалж: Блүүмбэрг

Эдийн засгийн салбараар нь харвал өсөлт харилцан адилгүй байна. Гэхдээ бүгд өсөлттэй байгаа нь хувьцаанаас өөр хөрөнгө оруулалтын сонголт бага байсны дохио гэлтэй. Хүү буурснаар хадгаламж, бонд гэх мэт тогтмол өгөөж бүхий хөрөнгө оруулалтын хэрэгслүүдээс хувьцаа, түүхий эд, крипто валют зэрэг хэрэгслүүдрүү хөрөнгийн урсгал явагдсан байна.

SP500 индексийн эдийн засгийн секторын задаргаа



Эх сурвалж: Блүүмбэрг

Тэгвэл цар тахлын үед хэрэгжүүлж буй засгийн газар болон төв банкуудын бодлого хэзээ, хэрхэн өөрчлөгдөх нь цаашид зах зээлийн чиглэлийг заах болно. Оны эцсийн байдлаар харвал ихэнх улс орнуудад бодлогын шилжилт хийгдэж эхэлсэн харагдаж байна. Дэлхийн голлох бэнчмарк болох АНУ-ын ЗГ-ын бондын өгөөж өсөж эхэлсэн нь ирээдүйд хүү өсгөх, мөнгөний нийлүүлэлт хумигдах зэрэг мөнгөний хатуу бодлогыг АНУ-ын Холбооны Нөөцийн Банкнаас хэрэгжүүлнэ гэсэн хүлээлттэй холбоотой. АНУ-ын төв банкны хувьд инфляцыг 2%-д онилдог бол 2021 оны эцэст инфляцын түвшин нь 4.7%-д хүрч өссөн учраас бодлогын хүүг өсгөхөөс өөр аргагүйд хүрч байна. Дэлхийн бусад томоохон улс орнууд мөн адил хүүгээ өсгөж эхэлсэн байна. Үүнд: Англи, Өмнөд Солонгос, Австрали гэх мэт улсуудыг дурдаж болно.


10 жилийн хугацаатай АНУ-ын засгийн газрын бондын өгөөж



Эх сурвалж: Блүүмбэрг

Монгол улсын хувьд 2021 оны эцсийн байдлаар инфляцын түвшин 13.4%-д хүрч өсөөд байгаа бөгөөд төв банкнаас инфляцыг нийлүүлэлтийн гаралтай гэж үзэн бодлогын хүүг өсгөхгүй хэвээр хадгалсаар байна. 2022 оны 2-р хагас гэхэд бодлогын хүү төв банкны зорилтот түвшин болох $6\pm 2\%$ -д хүрэх төсөөлөлтэй байгаа талаар мөн дурдсан байдаг.


Монголбанкны бодлогын хүү болон инфляцын хамаарал



Эх сурвалж: Монгол Банк

Хадгаламжийн хүү инфляцын түвшнээс бага байвал хадгаламжид байгаа мөнгөний үнэ цэнэ буурч байгаа хэрэг болно. Өөрт байгаа мөнгөний үнэ цэнийг хадгалахийн тулд инфляцаас өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалт хайх шаардлага хүн бүхэнд тулгарсан. Энэ шаардлага нь 2021 оны хөрөнгийн зах зээлийн тэсрэлтийн шалтгаан болжээ.

Монголын Хөрөнгийн Биржийн ТОП-20 индекс



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

2022 ОНЫ ТӨСӨӨЛӨЛ

Дэлхий даяар инфляцын түвшин хэт өндөр байгаа нь төв банкуудыг мөнгөний бодлогоо хатууруулах гол шалтгаан болж байна. Мөнгөний хатуу бодлого хэрэгжсэнээр хүүгийн түвшин өсөх, бизнесүүдийн ашигт ажиллагаа буурах, зээлийн олдоц муудах, эдийн засгийн өсөлт удаашрах, цаашлаад хөрөнгийн зах зээлд сөргөөр нөлөөлөх хандлагатай.

ДНБ болон инфляцын өсөлтийн таамаглал (улсаар)


Макро үзүүлэлт	Улс	2021	2022	2023
Бодит ДНБ жилийн өсөлт	Дэлхий	5.9%	4.3%	3.6%
	АНУ	5.6%	3.8%	2.5%
	БНХАУ	8.1%	5.2%	5.3%
инфляцын жилийн өсөлт	Дэлхий	4.3%	4.1%	2.8%
	АНУ	4.7%	4.6%	2.4%
	БНХАУ	0.9%	2.2%	2.2%

Эх сурвалж: Блүүмбэрг

2022 онд мөнгөний хатуу бодлогын нөлөөгөөр инфляцын түвшин буурах хүлээлттэй байна. Гэвч Орос Украин дайны мөргөлдөөн болон Мөнгөний бодлогын өөрчлөлт нь хөрөнгийн зах зээлд сөргөөр нөлөөлөх магадлал өндөр байгаа тул хөгжингүй орнуудын хөрөнгийн зах зээлд томоохон савлагаа үүсэх магадлалтай.

Өнгөрсөн онд БНХАУ-ын мөнгөний бодлого болон хөрөнгийн зах зээлийн хөдөлгөөн бусад орнуудтай харьцуулахад ихээхэн ялгаатай байсан. БНХАУ-ын хувьд барилгын салбарын удаашрал, өвлийн олимптой холбоотой цар тахлын эсрэг хатуу дэглэм зэргээс үүдэлтэй эдийн засгийн өсөлт нь удаашрах шинж тэмдгүүд ажиглагдаж байна. Үүний эсрэг БНХАУ-ны зүгээс бодлогын хүүгээ бууруулж байгаа нь бусад улс орнуудаас ялгаатай үйлдэл болж байна. Хятадын хөрөнгийн зах зээл засгийн газраас нь хэрэгжүүлсэн монополийн эсрэг болон технологийн компаниудын эсрэг бодлогоос үүдэн уналттай байсан. Тэгвэл 2022 онд энэ дүр зураг өөрөөр эргэх боломжтой харагдаж байгаа бөгөөд Хятадын хөрөнгийн зах зээл өсөлтөөрөө тэргүүлэх ч магадлалтай. Тиймээс БНХАУ-ын засгийн газрын бодлого болон АНУ-тай хийж буй худалдааны дайны байр байдлыг сайтар ажиглах шаардлагатай

БНХАУ-ын хөрөнгийн захын хөдөлгөөн




Эх сурвалж: Блүүмбэрг

Орос Украин дайны мөргөлдөөнөөс үүдэн дэлхийн хөрөнгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд ажиглагдахаар байна. Орос улсад үүсгэсэн бусад орнуудын эдийн засгийн хориг нь хөрөнгийн зах зээлийн эрсдэлийн түвшинг нэмснээр хөрөнгө оруулагч нар тодорхойгүй байдлаас хөрөнгөө хамгаалах үүднээс түүхий эдийн хөрөнгө оруулалтууд нэмэгдэх хандлагатай байна.

Монгол улсын 2021 оны ДНБ өсөлт 4.6% орчимд гарах хүлээлттэй байна. Азийн Хөгжлийн Банк болон Дэлхийн Банкны төсөөллөөс харвал 2022 онд Монгол улсын ДНБ өсөлт 6%-7.5% хооронд байх төлөвтэй. Бодлогын хүү болон хадгаламжийн хүү нам дор түвшинд байгаа, банкуудын хөрвөх чадвар өндөр байгаа тохиолдолд хадгаламжаас хөрөнгийн зах зээлрүү мөнгөний урсгал үргэлжлэх боломжтой харагдаж байна. Эзэмшиж буй төв банкны үнэт цаасны (ТБҮЦ) хэмжээгээр банкуудад байгаа илүүдэл мөнгөний хэмжээг баримжаалж болдог. Тэгвэл 2021 оны 11-р сарын эцсийн байдлаар банкууд дээр нийт ₮8.9 их наядын ТБҮЦ байгаа нь цар тахлын өмнөх үеэс даруй хоёр дахин өндөр дүн юм.

Банкуудын эзэмшиж буй төв банкны үнэт цаасны хэмжээ (ТБҮЦ)



Эх сурвалж: Монгол Банк

2022 онд Монголын хөрөнгийн зах зээл идэвхтэй байх хүлээлттэй байна. Хүлээгдэж буй томоохон банкуудын IPO-с гадна компанийн бонд, засгийн газрын бондын арилжаа идэвхжих болов уу.

Үндэсний Хувьчлалын Сангийн хувьд 2022 онд Монгол улсын инфляцын түвшин болон төгрөгийн ханшийн уналтаас хамгаалах зорилгоор зарим нэг гаднын хөрөнгө оруулалтуудыг нэмэгдүүлэх замаар багцын эрсдэлийг бууруулахад анхаарч ажиллах болно

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“Үндэсний хувьчлалын сан” хамтын ХОС ХХК -ийн Нэгж эрх эзэмшигчдэд

Санхүүгийн тайлангийн аудитын талаарх тайлан

Санал дүгнэлт

“Үндэсний хувьчлалын сан” хамтын ХОС ХХК (“ХОС” гэх)-ийн дараах тайлангуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийлээ:

- 2021 оны 12-р сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан;
- Энэ өдрөөр тасалбар болсон жилийн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангууд; болон
- Нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хүраангуйг агуулсан санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь “ХОС”-ийн 2021 оны 12-р сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”) -ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (“АОУС”) -ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл (“НБЕЗОУСЗ”) -ийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм (Хараат бус Байдлын Олон Улсын Стандартыг багтаасан) болон Монгол улсад мөрдүүлэхээр шаарддаг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу “ХОС”-аас хараат бус байсан бөгөөд НБЕЗОУСЗ-ийн дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагын дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж бид найдаж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудлууд нь бидний мэргэжлийн дүгнэлтээр тайлант жилийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их ач холбогдолтой байсан асуудлууд юм. Эдгээр асуудлыг бид санхүүгийн тайланд бүхэлд нь аудит хийж, дүгнэлт гаргахдаа авч үзсэн бөгөөд бид эдгээр асуудлаар тусад нь дүгнэлт өгөхгүй.

Аудитын гол асуудал

Аудитын хариу

1 Санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн хэмжилт

“ХОС”-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан дах Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгөд арилжаалах зорилгоор эзэмшиж буй, хөрөнгийн бирж дээр нээлттэй арилждаг өмчийн болон өрийн хэрэглүүр дэх хөрөнгө оруулалтууд багтдаг бөгөөд ХОС-н удирдлага энэхүү санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн хэмжилтийг гүйцэтгэхэд тооцоолол болон шийдэл шаарддаг гэж үзсэн тул аудитын гол асуудалд оруулсан. Хавсаргасан санхүүгийн тайлангийн Тэмдэглэл 11-аас үзнэ үү.

Бид санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн тооцооллыг үнэлэхдээ нээлттэй арилжаалагддаг гадаад болон дотоодын хөрөнгийн бирж дээрх арилжааны түүхэн мэдээлэл болох хувьцааны нээлт хаалтын ханш, тоо ширхэг, арилжааны давтамж зэргийг олж танилцсан. Мөн тэдгээр компаниудын үйл ажиллагаатай холбоотой томоохон үйл явдал, биржээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг судалсан.

BDO AUDIT LLC, a Mongolian Limited Liability Company, is a member of BDO International Limited, a UK company limited by guarantee, and forms part of the international BDO network of independent member firms.

Монгол Улсын хягаарлагдмал хариуцлагатай компани болох БДО АУДИТ ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн гишүүн, олон улсын БДО сүлжээний бие даасан гишүүн байгууллагуудын нэг юм.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээлэлд үүрэг хариуцлага хүлээдэг. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд бидний аудиторын тайлан ордоггүй.

Санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамардаггүй бөгөөд бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилтын дүгнэлт гаргахгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттайгаа холбогдуулан бидний хүлээх үүрэг хариуцлага бол бусад мэдээллийг уншиж, ингэснээр бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитаар олж авсан бидний мэдлэг эсвэл өөр хэлбэрээр материаллагаар буруу илэрхийлэгдсэн байж болох эсэх тухай материаллаг үл нийцлийг авч үзэхэд оршдог. Бид өөрсдийн гүйцэтгэсэн ажил дээрээ суурилан энэхүү бусад мэдээлэл нь материаллаг буруу илэрхийлэлтэй байна гэж дүгнэвэл тухайн бодит байдлыг тайлагнахыг биднээс шаарддаг. Бидэнд ингэж тайлагнах зүйл байхгүй болно.

Санхүүгийн тайланд Удирдлага ба Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах, болон алдаа юм уу заль мэхнээс үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлан бэлтгэх боломж бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг тодорхойлох нь удирдлагын үүрэг хариуцлага юм.

Санхүүгийн тайланг бэлтгэж байхдаа удирдлага нь "ХОС"-г татан буулгах юм уу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд удирдлага өөдрөг төсөөллөөр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх "ХОС"-ийн чадамжийг үнэлж, шаардлагатай бол өөдрөг төсөөлөлтэй холбоотой асуудлуудын талаар тодруулга хийх, нягтлан болох бүртгэлийн өөдрөг төсөөллийн сүүрийг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ.

Засаглах удирдлага нь "ХОС"-ийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Заль мэх эсвэл алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ ангид эсэх талаарх үл үндэслэлтэй баталгаажилтыг олж авч, өөрийн санал дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй баталгаажилт нь баталгаажилтын өндөр түвшин боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг цаг ямагт илрүүлж байна гэж амласан баталгаа гаргадаггүй. Алдаа зөрчил нь заль мэхнээс эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд хэрэв тэр нь дангаараа эсвэл нийлэхээрээ санхүүгийн тайланд үндэслэн түүнийг хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуу хийсэн аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын түршид мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Заль мэх эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Заль мэхнээс үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь заль мэхэнд хуйвалдаан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоох явдлууд орсон байж болно.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага (үргэлжлэл)

- Компанийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй байдлыг үнэлдэг.
- Мөн олж авсан аудитын нотолгоонд үндэслэн компанийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөлүүд нь компанийг өөдрөг төсөөллөө үргэлжлүүлэхээ зогсооход хүргэх нөлөө үзүүлж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулга ба санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ ба хугацаа, аудитынхаа явцад олж илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон зөрчил дутагдлыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлуудаар засаглах эрх бүхий удирдлагатай харилцдаг.

Бид хараат бус байдлын тухай холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн мэдэгдлээр засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийг хангадаг ба мөн бид эдгээр хүмүүстэй бүх харилцаа холбоо болон шаардлагатай гэж үзвэл хариу арга хэмжээ зэрэг бидний хараат бус байдлын хүрээнд бодолцож үзвэл зохих асуудлаар харилцдаг.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад гол асуудлууд гэж үздэг. Хууль, дүрэм журмаар аливаа асуудлыг олон нийтэд мэдээлэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд аудиторын тайланд тухайн асуудлыг мэдээлэх нь тухайн мэдээллээс олон нийтийн хүртэх үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлыг аудиторын тайландаа тодорхойлдог.



Л. БАЯРЦОГЗОЛ
УЛААНБААТАР ХОТ
"БДО Аудит" ХХК
Монгол улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Юнескогийн гудамж, Нарны зам-62
Юнион Бюлдинг В блок, 1502 тоот өрөө

Огноо: 2022.03.24

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

	2021 он мян.төг	2020 он мян.төг
Хөрөнгө		
Эргэлтийн хөрөнгө		
Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	8,948,174	2,069,774
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	657,470	2,036,255
Бусад авлага	-	20,100
Урьдчилж төлсөн төлбөр	-	31
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	251,243	998,539
Нийт хөрөнгө	9,856,887	5,124,669
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Худалдааны болон бусад өглөг	25,046	223,641
Орлогын татварын өглөг	7,235	57
Нийт богино хугацаат өр төлбөр	32,281	223,698
Урт хугацаат өр төлбөр		
Хойшлогдсон татварын өглөг	498,902	22,507
Нийт урт хугацаат өр төлбөр	498,902	22,507
Нийт өр төлбөр	531,183	246,205
Цэвэр хөрөнгө		
Хувь нийлүүлсэн хөрөнгө	5,000,000	5,000,000
Хуримтлагдсан ашиг	4,325,704	(121,506)
Нийт цэвэр хөрөнгө	9,325,704	4,878,494
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө	9,856,887	5,124,699

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

	2021 он мян.төг	2020 он мян.төг
Ашиг алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн хүүгийн орлого	22,102	-
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн хүүгийн орлого	181,771	66,244
Ногдол ашгийн орлого	89,446	-
Мөнгөн хөрөнгө дэх гадаад валютын ханшийн зөрүүнийгийн олз	379	-
Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өсөлтийн олз	4,935,265	225,481
Нийт үйл ажиллагааны орлого	5,228,963	291,725
ХОМК-ийн үйлчилгээний зардал	(202,909)	(21,813)
Кастодианы үйлчилгээний зардал	(27,762)	(3,045)
Бусад зардал	(39,188)	(359,227)
Нийт үйл ажиллагааны зардал	(269,859)	(384,227)
Татварын өмнөх ашиг	4,959,104	(92,502)
Орлогын албан татварын зардал	(511,894)	(29,131)
Тайлант жилийн ашиг	4,447,210	(121,633)
Нэгж эрхэд ногдох ашиг	88.94	(11.68)

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

	Хувь нийлүүлсэн хөрөнгө мян.төг	Хуримтлагд сан ашиг мян.төг	Нийт өмч мян.төг
2021 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	5,000,000	(121,506)	4,878,494
Тайлант жилийн ашиг	-	4,447,210	4,447,210
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй ашиг	-	4,447,210	4,447,210
Гаргасан нэгж эрх	-	-	-
2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	5,000,000	4,325,704	9,325,704
2020 оны 01 сарын 01-ний эхлэлтийн тайлан	250,000	127	250,127
Тайлант жилийн ашиг	-	(121,633)	(121,633)
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй ашиг	-	(121,633)	(121,633)
Гаргасан нэгж эрх	4,750,000	-	4,750,000
2020 оны 12 сарын сарын 31-ний үлдэгдэл	5,000,000	(121,506)*	4,878,494

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	2021 он мян.төг	2020 он мян.төг
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Тайлант жилийн ашиг	4,447,210	(121,633)
Тохируулга:		
Бодит үнэ цэн нь ашиг, алдагдлаар илэрхийлэгдсэн хөрөнгө оруулалтын үнэлгээний хэрэгжээгүй олз	(203,873)	(66,244)
Хүүгийн орлого	(89,446)	-
Гадаад валютын ханшийн зөрүүгийн хэрэгжээгүй олз	(379)	-
Орлогын албан татвар зардал	511,894	29,131
Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үндсэн үйл ажиллагааны алдагдал	4,665,406	(158,746)
Бусад авлагын бууралт	11,628	39,875
Урьдчилж төлсөн төлбөрийн (бууралт)	31	-
Хөрөнгө оруулалтын (өсөлт)	(5,528,368)	(4,069,774)
Худалдааны болон бусад өглөгийн өсөлт (бууралт)	(218,507)	223,639
Үндсэн үйл ажиллагаанд зарцуулсан мөнгө	(1,069,810)	(3,965,006)
Хүлээн авсан ногдол ашиг	80,363	-
Хүлээн авсан хүү	241,772	3,391
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(747,675)	(3,961,615)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Гаргасан нэгж эрх	-	4,750,000
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-	4,4750,00
Тайлант жилд бий болсон/ (зарцуулсан) нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(747,675)	788,385
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	998,539	210,154
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө	379	-
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	251,243	998,539